



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/169/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangaiaudit.gov.mn

2026.02.07 № 10

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд аймгийн хэмжээнд 605 төлөвлөлтийн нэгж талбарын 942.56 га газрыг олгохоор төлөвлөснөөс 535 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 339.29 га газрыг олгож, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 40, Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 18, төсөл хөтөлбөрийн 2 нийт 60 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлснээр улсын төсвөөс 1,457,964.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,420,095.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын 113 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт,

төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргаас 91.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	102,927,361.07	78,935,836.11
33	АВЛАГА	77,752,772.40	52,499,037.44
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	77,752,772.40	42,422,598.44
335	Байгууллага	-	10,076,439.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	10,076,439.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,174,588.67	26,436,798.67
354	Хангамжийн материал	25,174,588.67	26,436,798.67
35410	Бичиг хэргийн материал	1,704,100.00	5,797,250.00
35420	Аж ахуйн материал	23,463,812.67	20,409,412.67
35440	Түлш, шатах тослох материал	6,676.00	230,136.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,821,844,039.98	1,777,940,510.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,821,844,039.98	1,777,940,510.12
392	Биет хөрөнгө	1,054,219,039.87	1,010,828,843.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	847,317,023.86	847,317,023.86
39202	Хуримтлагдсан элэгдэл /Барилга, байгууламж, орон сууц	(117,921,562.56)	(137,575,156.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	191,490,000.00	191,490,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл/Авто-тээврийн хэрэгсэл	(96,645,624.78)	(126,977,708.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	424,543,449.55	427,158,256.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(212,794,668.82)	(223,603,245.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,884,700.00	62,556,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,654,277.38)	(29,536,527.52)
393	Биет бус хөрөнгө	767,625,000.11	767,111,666.71
39301	Программ хангамж	2,200,000.00	2,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(604,999.89)	(1,118,333.29)
39303	Бусад биет бус хөрөнгө	647,700,000.00	647,700,000.00
39305	Газар эзэмших эрх	118,330,000.00	118,330,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,924,771,401.05	1,856,876,346.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ	1,924,771,401.05	1,856,876,346.23
51	Засгийн газрын хувь оролцоо	1,924,771,401.05	1,856,876,346.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	514,637,915.32	514,637,915.32
51101	- төрийн	514,637,915.32	514,637,915.32
512	Хуримтлагдсан үр дүн	1,282,183,176.09	1,214,288,121.27
51220	Тайлант үеийн үр дүн	659,122,503.81	(67,895,054.82)
51210	Өмнөх үеийн үр дүн	623,060,672.28	1,282,183,176.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,950,309.64	127,950,309.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,924,771,401.05	1,856,876,346.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,683,229,439.70	2,075,318,846.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	837,547,982.45	190,346,008.44
120	Нийтлэг татварын бус орлого	837,547,982.45	190,346,008.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,578,668.90	116,967,458.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,578,668.90	115,556,442.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,411,016.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	718,969,313.55	73,378,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,845,681,457.25	1,884,972,838.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,389,346,200.00	1,363,811,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,389,346,200.00	1,363,811,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	452,222,840.00	515,895,738.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	433,450,718.00	515,895,738.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,772,122.00	-
1330	Төсвийн захирагчдаас	4,112,417.25	5,265,700.00
133003	Хөрөнгийн	4,112,417.25	5,265,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,022,227,357.49	2,143,213,901.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,022,227,357.49	2,143,213,901.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,834,263,558.34	2,030,923,555.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,308,521,171.64	1,505,168,840.99
210101	Үндсэн цалин	616,589,143.91	676,576,470.00
210102	Нэмэгдэл	333,128,741.73	413,560,866.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,802,000.00	83,860,000.00
210104	Урамшуулал	87,921,450.00	71,324,292.00
210105	Гэрээт ажлын хөлс	210,079,836.00	259,847,212.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,782,921.17	194,342,775.68
210201	Тэтгэврийн даатгал	111,887,450.00	130,223,331.36
210202	Тэтгэмжийн даатгал	13,095,867.02	15,293,448.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,013,482.55	11,428,269.70
210204	Ажилгүйдлийн даатгал	6,330,279.61	7,471,353.78
210205	Эрүүл мэндийн даатгал	25,455,841.99	29,926,371.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,002,790.44	60,101,505.21
210301	Гэрэл, цахилгаан	4,010,673.00	5,244,191.00
210302	Түлш, халаалт	53,529,904.00	53,529,904.00
210303	Цэвэр, бохир ус	2,462,213.44	1,327,410.21
2104	Хангамж, бараа материалын зардал	32,417,591.25	31,747,148.00
210401	Бичиг хэрэг	13,132,757.25	3,893,050.00
210402	Тээвэр, шатахуун	18,361,324.00	21,919,864.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,400.00	773,434.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	338,000.00

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	492,610.00	4,794,300.00
210408	Бараа материал акталсны зардал	272,500.00	28,500.00
2105	Нормативт зардал	116,550.00	95,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	116,550.00	95,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,026,000.00	25,112,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,955,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	10,000,000.00
210604	Урсгал засвар	5,071,000.00	15,112,850.00
2107	Томилолт, зочны зардал	46,736,000.00	32,330,000.00
210702	Дотоод албан томилолт	46,736,000.00	32,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,672,300.00	3,362,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,750,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,200.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,200.00	308,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	13,900.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	780,000.00
210807	Газрын төлбөр	-	348,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,988,233.84	178,661,935.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,846,420.34	44,459,856.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,141,813.50	134,202,079.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,963,799.15	112,290,345.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,493,128.00	2,343,016.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,867,434.00	932,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,125,894.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	499,800.00	1,411,016.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,308,800.04	93,170,919.36
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	22,322.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,286,478.04	93,170,919.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,161,871.11	16,776,410.16
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	20,161,871.11	16,776,410.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)	661,002,082.21	(67,895,054.82)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,879,578.40	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,879,578.40	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI = IV - V)	(1,879,578.40)	-
7	НИЙТ ҮР ДҮН (VII = III + VI)	659,122,503.81	(67,895,054.82)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,966,429,016.74	2,031,504,770.40
I.I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,966,429,016.74	2,031,504,770.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,859,976.74	151,797,632.40
120	Нийтлэг татварын бус орлого	124,859,976.74	151,797,632.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,859,976.74	151,797,632.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,859,976.74	150,386,616.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,411,016.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,841,569,040.00	1,879,707,138.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,389,346,200.00	1,363,811,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,389,346,200.00	1,363,811,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	452,222,840.00	515,895,738.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	433,450,718.00	515,895,738.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,772,122.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,897,789,416.74	2,014,584,770.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,897,789,416.74	2,014,584,770.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,709,825,617.59	1,902,294,424.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,308,521,171.64	1,515,245,279.99
210101	Үндсэн цалин	616,589,143.91	676,576,470.00
210102	Нэмэгдэл	333,128,741.73	423,637,305.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,802,000.00	83,860,000.00
210104	Урамшуулал	87,921,450.00	71,324,292.00
210105	Гэрээт ажлын хөлс	210,079,836.00	259,847,212.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,782,921.17	194,342,775.68
210201	Тэтгэврийн даатгал	111,887,450.00	130,223,331.36
210202	Тэтгэмжийн даатгал	13,095,867.02	15,293,448.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,013,482.55	11,428,269.70
210204	Ажилгүйдлийн даатгал	6,330,279.61	7,471,353.78
210205	Эрүүл мэндийн даатгал	25,455,841.99	29,926,371.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,606,299.44	46,158,199.21
210301	Гэрэл, цахилгаан	4,010,673.00	5,244,191.00
210302	Түлш, халаалт	44,133,413.00	39,586,598.00
210303	Цэвэр, бохир ус	2,462,213.44	1,327,410.21
2104	Хангамж, бараа материалын зардал	19,906,710.00	26,708,034.00
210401	Бичиг хэрэг	923,700.00	3,019,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,368,000.00	22,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,400.00	773,434.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	338,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	456,610.00	427,600.00
2105	Нормативт зардал	127,750.00	84,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	127,750.00	84,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,071,400.00	26,032,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,400.00	920,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	10,000,000.00
210604	Урсгал засвар	5,071,000.00	15,112,850.00
2107	Томилолт, зочны зардал	46,736,000.00	32,330,000.00
210702	Дотоод албан томилолт	46,736,000.00	32,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,672,300.00	3,362,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,750,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,200.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,200.00	308,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	13,900.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	780,000.00
210807	Газрын төлбөр	-	348,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,401,065.34	58,029,986.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал/Бараа үйлчилгээний бусад зардал	109,401,065.34	58,029,986.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,963,799.15	112,290,345.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,493,128.00	2,343,016.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,867,434.00	932,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,125,894.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	499,800.00	1,411,016.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,308,800.04	93,170,919.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,286,478.04	93,170,919.36
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	22,322.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,161,871.11	16,776,410.16
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	20,161,871.11	16,776,410.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III = I -II)	68,639,600.00	16,920,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	68,639,600.00	16,920,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,639,600.00	16,920,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,639,600.00	16,920,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(68,639,600.00)	(16,920,000.00)
XII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
XIII	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
XIV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 ОНЫ 01 САРЫН 01-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	514,637,915.32	127,950,309.64	623,060,672.28	1,265,648,897.24
C03	ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ	514,637,915.32	127,950,309.64	623,060,672.28	1,265,648,897.24
C09	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	659,122,503.81	659,122,503.81
C10	2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	514,637,915.32	127,950,309.64	1,282,183,176.09	1,924,771,401.05
D01	2025 ОНЫ 01-Р САРЫН 01-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	514,637,915.32	127,950,309.64	1,282,183,176.09	1,924,771,401.05
D03	ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ	514,637,915.32	127,950,309.64	1,282,183,176.09	1,924,771,401.05
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(67,895,054.82)	(67,895,054.82)
D10	2025 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	514,637,915.32	127,950,309.64	1,214,288,121.27	1,856,876,346.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
I	ОРЛОГЫН ДҮН (I)	1,457,964,800.00	1,514,198,016.40	(56,233,216.40)	103.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,999,800.00	150,386,616.40	(70,386,816.40)	187.98
120	Нийтлэг татварын бус орлого	79,999,800.00	150,386,616.40	(70,386,816.40)	187.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,999,800.00	150,386,616.40	(70,386,816.40)	187.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,999,800.00	150,386,616.40	(70,386,816.40)	187.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,377,965,000.00	1,363,811,400.00	14,153,600.00	98.97
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,377,965,000.00	1,363,811,400.00	14,153,600.00	98.97
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,377,965,000.00	1,363,811,400.00	14,153,600.00	98.97
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,457,964,800.00	1,421,027,097.04	36,937,702.96	97.47
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,457,964,800.00	1,421,027,097.04	36,937,702.96	97.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,457,964,800.00	1,421,027,097.04	36,937,702.96	97.47

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,445,285,800.00	1,420,095,097.04	25,190,702.96	98.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,172,629,100.00	1,158,317,744.00	14,311,356.00	98.78
210101	Үндсэн цалин	646,122,400.00	676,576,470.00	(30,454,070.00)	104.71
210102	Нэмэгдэл	390,258,900.00	326,556,982.00	63,701,918.00	83.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,578,800.00	83,860,000.00	(30,281,200.00)	156.52
210104	Урамшуулал	82,669,000.00	71,324,292.00	11,344,708.00	86.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,513,400.00	147,343,855.83	1,169,544.17	99.21
210201	Тэтгэврийн даатгал	99,463,700.00	99,884,490.85	(420,790.85)	100.42
210202	Тэтгэмжийн даатгал	12,262,400.00	11,724,173.59	538,226.41	95.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,131,200.00	7,191,600.50	(1,060,400.50)	117.30
210204	Ажилгүйдлийн даатгал	6,131,200.00	5,700,526.76	430,673.24	92.98
210205	Эрүүл мэндийн даатгал	24,524,900.00	22,843,064.13	1,681,835.87	93.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,158,200.00	46,158,199.21	0.79	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,188,800.00	5,244,191.00	(55,391.00)	101.07
210302	Түлш, халаалт	37,462,200.00	39,586,598.00	(2,124,398.00)	105.67
210303	Цэвэр, бохир ус	3,507,200.00	1,327,410.21	2,179,789.79	37.85
2104	Хангамж, бараа материалын зардал	3,383,900.00	2,563,862.00	820,038.00	75.77
210401	Бичиг хэрэг	1,246,600.00	1,122,000.00	124,600.00	90.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	855,900.00	433,882.00	422,018.00	50.69
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	471,100.00	263,000.00	208,100.00	55.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	410,300.00	344,980.00	65,320.00	84.08
2105	Нормативт зардал	115,700.00	84,700.00	31,000.00	73.21
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	115,700.00	84,700.00	31,000.00	73.21
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,700.00	164,150.00	6,550.00	96.16
210604	Урсгал засвар	170,700.00	164,150.00	6,550.00	96.16
2107	Томилолт, зочны зардал	2,344,600.00	2,340,000.00	4,600.00	99.80
210702	Дотоод албан томилолт	2,344,600.00	2,340,000.00	4,600.00	99.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	9,619,100.00	952,600.00	8,666,500.00	9.90

	үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,036,100.00	-	7,036,100.00	-
210802	Аудит, Баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	179,200.00	-	179,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,090,000.00	143,100.00	946,900.00	13.13
210804	Тээврийн хэрэгслийн татвар	308,200.00	308,200.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	59,100.00	33,000.00	26,100.00	55.84
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	591,500.00	120,000.00	471,500.00	20.29
210807	Газрын төлбөр	355,000.00	348,300.00	6,700.00	98.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,351,100.00	62,169,986.00	181,114.00	99.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,351,100.00	62,169,986.00	181,114.00	99.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,679,000.00	932,000.00	11,747,000.00	7.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,679,000.00	932,000.00	11,747,000.00	7.35
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	932,000.00	932,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,747,000.00	-	11,747,000.00	-
III	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
IV	АЖИЛЛАГСДЫН ТОО	41	41	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	3	3	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37	37	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	ОРЛОГЫН ДҮН	515,895,738.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	515,895,738.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	515,895,738.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	515,895,738.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	515,895,738.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	515,895,738.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,895,738.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,119,327.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	356,927,535.99
210102	Нэмэгдэл	97,080,323.99
210105	Гэрээт ажлын хөлс	259,847,212.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,998,919.85
210201	Тэтгэврийн даатгал	30,338,840.51
210202	Тэтгэмжийн даатгал	3,569,275.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,236,669.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,770,827.02
210205	Эрүүл мэндийн даатгал	7,083,307.76
2104	Хангамж, бараа материалын зардал	24,144,172.00
210401	Бичиг хэрэг	1,897,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	339,552.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	82,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,648,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,000,000.00
210604	Урсгал засвар	19,948,700.00
2107	Томилот, зочны зардал	29,990,000.00
210702	Дотоод албан томилот	29,990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,776,410.16
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,776,410.16
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	16,776,410.16

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **28,726.0** мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 28,726.0 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ✓ Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын эхний үлдэгдэл өмнөх онд худалдан авсан 18,649.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр дутуу тайлагнасан.
- ✓ Төрд учруулсан хохиролтой холбоотой 10,076.4 мянган төгрөгийн авлагыг үр дүнгийн тайланд зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь УСНББОУС 1, 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул бараа материалын тайланд залруулга хийлгэлээ.

Мөн аудитаар нийт **13,882.9** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,757.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12,125.4 мянган төгрөгийн зөрчил таслан зогсоож, арилгуулах 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 13,882.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **16,402.1** мянган төгрөгөөс бага, шинж чанарын хувьд материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тус байгууллагын 2025 оны 1-5 сарын шатахууны зарцуулалтыг автомашины нормоор тооцон жолоочийн тооцооны хуудас руу тулган шалгахад 1,757.5 мянган төгрөгийн шатахуун норм нормативаас хэтрэлттэй зарцуулагдсан байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 3-р хавсралтаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалыг мөрдөж, автомашины норм норматив хэтрүүлэн зарцуулсан 1,757.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

3.2.1 Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/05 дугаар захирамжаар МУЗГ-ын болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө, тухайн онд дэвшүүлсэн байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ аймгийн Засаг даргатай байгуулсан "Үр дүнгийн гэрээ"-г хангалттай хэрэгжүүлж, 2024 оны ажлаараа тэргүүлсэн газрын даргад нэг сарын цалин болох 2,049.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг зардлын эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийг мөрдөж, зардлыг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх

3.2.2 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025.03.27-ны өдрийн 109/ШШ2025/0010 дугаар шийдвэрээр "...Г.Энхбаярын 2024.04.18-2025.01.13-ны өдрийг хүртэл ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговорт 18,076,439 төгрөгийг аймгийн ГХБХБГ-ын даргаас гаргуулж, тус олговрын дүнгээс тооцон нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлж, бичилт хийлгэхийг" даалгасан байна. Тус шүүхийн шийдвэрийг үндэслэн 10,076,400 төгрөгийг байгууллагын төсвөөс Г.Энхбаярт олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийг мөрдөж, төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу тайлагнасан	1	18,649.6	1	18,649.6	-	-	1	18,649.6				
Төрд учруулсан хохиролтой холбоотой авлагыг зардлаар тайлагнасан	1	10,076.4	1	10,076.4	1	10,076.4	1	10,076.4				
ДҮН	2	28,726.0	2	28,726.0	1	10,076.4	2	28,726.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Автомашин шатахууны нормыг хэтрүүлэн зарцуулсан	1	1,757.5	1	1,757.5								
Зориулалт бус зарцуулсан	1	2,049.0			1	2,049.0						
ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийг мөрдөж ажиллаагүй	1	10,076.4			1	10,076.4						
Нийт дүн	3	13,882.9	1	1,757.5	2	12,125.4						